

2021 ОНЫ 5-Р САРЫН 17-ООС ЭХЛЭЖ СУРГУУЛЬ БА СУРГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ (ТОВЧ ТОЙМ)

Боловсрол, залуучууд ба спортын яамнаас 2021 оны 5-р сарын 10-ны өдөрт болсон Чех Улсын засгийн газрын хуралдаантай холбогдуулан дараагийн мэдээлэл гаргаж байна:

Сургууль ба сургуулийн барилга байгууламж дахь үйл ажиллагааг хязгаарлах тухай Эрүүл мэндийн яамнаас шинэчилсэн онцгой арга хэмжээ нь **2021 оны 5-р сарын 17-ны өдрөөс эхлэн хүчинтэй** болох ба дагаж мөрдөгдөнө ([ЭНД](#) зарлан нийтлэгдэнэ). Энэхүү онцгой арга хэмжээ нь одоогийн байдалтай харьцуулахад дараахь зүйлүүдийг засч залруулж байна:

- **Суурь сургуульд**
 - Чех Улсын бүх нутаг дэвсгэрт **1 дүгээр үе шатны сурагчид нь долоо хоногоор ээлжлэхгүйгээр** биечлэн сургуульд явах болно, зэрэгцээгээр нь бэлтгэх ангийн хүүхэд ба тусгай сургуулийн бэлтгэх ангийн хүүхэд нь долоо хоногоор ээлжлэхгүйгээр сургуульдаа биечлэн явах болно,
 - Карловы Вары, Храдец Кралове, Либерец, Пардубице, Плзень, Стредочески мужууд ба Прага нийслэл хотод **2 дугаар үе шатны сурагчид нь долоо хоногоор ээлжлэхгүйгээр** сургуульдаа биечлэн явах болно, бусад мужуудад 2 дугаар үе шатны сурагчид нь долоо хоногоор ээлжлэж сургуульдаа явах болно,
 - Чех Улсын бүх нутаг дэвсгэрт нэгэн төрлийн анги ба бүлгэмүүд нь заавал байх ёсгүй болно.
- **Сургуулийн хичээлийн бус цагийн бүлгэмүүд ба сургуулийн клубууд дээр**
 - Чех Улсын бүх нутаг дэвсгэрт байсан хязгаарлалт нь цуцлагдаж байна. Үйл ажиллагаанууд хэвийн горимд явагдана, нэгэн төрлийн анги ба бүлгэмүүд нь заавал байх ёсгүй болно¹,
 - сонгогдсон мэргэжилтэй эцэг эхийн хүүхдүүдэд сургалт хангах үүрэг нь цуцлагдана, юу вэ гэхэд, 1 дүгээр үе шатны бүх сурагчид нь сургуульдаа буцах болно.
- **Сурагчдад ба оюутнуудад ковидийн эсрэг тест хийх тухай Эрүүл мэндийн яамны онцгой арга хэмжээ нь одоогийн байдалтай харьцуулахад өөрчлөгдөж, урьдчилан сэргийлэх эсрэг төрөгчийн тестийн давтамж нь 2021 оны 5-р сарын 17-оос хүчинтэйгээр** дараагийн аргаар өөрчлөгдөх болно:
 - **долоо хоногт хоёр удаа** Өмнөд Чехийн мужид, Усти мужид, Оломоуц мужид, Морави-Силезийн мужид, Өмнөд Моравийн мужид, Злин мужид, Высочина мужид суурь сургуулийн 2 дугаар үе шатны сурагчид нь үүнд хамаарагдана, тэгэхдээ сурагчийн сургуульд ирсэн анхны өдөрт ковидийн эсрэг тест хийх бөгөөд нэг долоо хоногт нь хамгийн багаар – 2 өдрийн дараа ба хамгийн ихээр 3 ажлын өдрийн дараа энэ тестийг давтах болно,
 - **долоо хоногт нэг удаа** бусад тохиолдолд, сурагч эсвэл оюутан нь сургуульд байх долоо хоногт биечлэн ирсний анхны өдөрт нь энэ тестийг хийх болно.

Урьдчилан сэргийлэх ковидын эсрэг тестийг сургууль дээр ирсний дараа шууд хийдэг. Хэрэв сурагч, оюутан тухайн сургууль дээр тест өгөх өдөр байхгүй бол түүний сургуульд ирсэн өдөрт нь энэ тестийг хийх болно.
 - **RT-PCR шинжилгээний хувьд давтамжийн өөрчлөлт гарч байна (эсрэг төрөгчийн тестийг RT-PCR шинжилгээгээр орлуулах гэж шийдсэн сургууль эсвэл сургуулийн байгууламжинд) 14 хоногт 1 удаа энэ шинжилгээ гарах болно.** Энэ RT-PCR шинжилгээний давтамж нь бүх мужуудад хүчинтэй, эсрэг төрөгчийн тестийг долоо хоногт хоёр удаа хийж байсан мужуудад ч гэсэн адилхан хүчинтэй. Зэрэгцээгээр нь RT-PCR шинжилгээ хийж байхдаа тухайн долоо хоногт сурагч нь сургуульд ирсний анхны өдөрт заавал энэ шинжилгээ гарах ёсгүй; энэ тохиолдолд тухайн хугацаанд энэ шинжилгээ өөр цагаар зохицуулж болно, зөвхөн сурагч болгонд RT-PCR шинжилгээний тогтоосон давтамжийг харгалзах хэрэгтэй.

Эрүүл мэндийн яамны 2021 оны 5-р сарын 4-ний өдрийн онцгой арга хэмжээний дагуу, бичиг хэргийн дугаар:

MZDR 15757/2020-50/MIN/KAN ([ЭНД](#)), 2021 оны 5-р сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэйгээр тогтоож байна: гадаа талбайд хамар ба амны хаалтыг заавал зүүх шаардлагагүй, бусад хүнээс 2 метр зай баримтлах хэрэгтэй, нэг өрхийн гишүүн нь ойролцоо явж болно. Тиймээс гадуур салхилах эсвэл сургуулийн цэцэрлэгт алхах эсвэл үлдэх үед оюутан эсвэл ажилчид нь хамар, амны хаалтыг заавал зүүх шаардлагагүй, бусад хүмүүсээс 2 метрийн зайг баримтлах ёстой. **Доторхи орон зайд цаашид ч гэсэн хамар ба амны хаалтыг зүүх үүрэгтэй, зөвшөөрөгдсөн онцгой зүйлүүд байна** (жишээлвэл, хүүхдийн цэцэрлэгийн хүүхэд амны хаалтыг зүүх хэрэггүй).

Боловсрол, залуучууд ба спортын яам, 2021 оны 5 дугаар сарын 10-нд